

# МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... дугаар  
сарын ... -ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

## Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Мандал голомт” ХХК-ийн 2024 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн 195 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын “Мандал Голомт” ХХК-ийн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, 2 дугаар хавсралтаар баталсан тарифыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Мандал голомт” ХХК (С.Дарамдад)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн “Тариф батлах тухай” 498 дугаар тогтоолын хавсралтын 1 дүгээр мөрөнд заасан төсөвт байгууллагын халаалтын тариф, 3 дугаар мөрөнд заасан төсөвт байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулааны тарифыг тус тус хүчингүй болгосугай.

4. Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн “Тариф батлах тухай” 498 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар мөрөнд заасан үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тариф, 3 дугаар мөрөнд заасан үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулааны тариф, 4 дүгээр мөрөнд заасан орон сууцны халаалтын тариф, 5 дугаар мөрөнд заасан дулааны эрчим хүчний үйлчилгээний тарифыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн тус тус хүчингүй болгосугай

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

ДАРГА

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

П.ТОВУУДОРЖ

ЗОХИЦУУЛАГЧ

Л.ДАШМЯГМАРЖАВ

ЗОХИЦУУЛАГЧ

Ц.НОРОВЖАМЦ

ЗОХИЦУУЛАГЧ

Д.ЦОГОО

Эрчим хүчний зохицуулах хорооны  
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын 1-р хавсралт

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД  
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ**

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын “Мандал Голомт” ХХК-ийн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	2,994.00	
	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ	50,399.20
		тогтмол	Төг/м <sup>3</sup>	1,677.00
2	Төсөвт байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м <sup>3</sup>	3,000.00	

2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын 2-р хавсралт

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН  
НЭГЖ, БАЙГУУЛЛАГА БОЛОН АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ  
ДУЛААНЫ ТАРИФ**

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын “Мандал Голомт” ХХК-ийн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	2,603.50	
	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ	43,825.40
		тогтмол	Төг/м <sup>3</sup>	1,458.20
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м <sup>3</sup>	3,000.00	
3	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “0”-ын ерөөний халаалт хамаарна)	Төг/м <sup>2</sup>	1,400.00	
4	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	41 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	5,000.00
		41-81м <sup>2</sup> талбайтай айл өрх	Төг/сар	8,000.00
		81 м <sup>2</sup> -с дээш талбайтай айл өрх	Төг/сар	12,000.00

---oOo---